

**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД  
УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛААР  
ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭНД ХИЙСЭН  
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАНИЛЦУУЛГА  
/2024 оны эхний хагас жилийн байдлаар /**

2024 оны 06 дугаар сарын 12-ны өдөр

**Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго**

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд эхний хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн зорилтот түвшинг хүрсэн түвшинтэй нь харьцуулан үр дүнг үнэлэх, зөвлөмж, дүгнэлт гаргах, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангах, төлөвлөсөн зорилго, зорилтыг бүрэн биелүүлэхэд дэмжлэг үзүүлэхэд оршино.

**Хоёр. Хяналт- шинжилгээ, үнэлгээний арга зүй**

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээ хийхдээ Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захирагааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов.

**Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн**

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам Монгол Улсын Их Хурлын 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор батлагдсан Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар тусгагдсан нийт 3 зорилгын 15 арга хэмжээний хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Үнэлгээг 2023 оны жилийн эцсийн байдлаар Засгийн газрын хэрэг эрхлэх газрын хяналт-шинжилгээ, үнэлгээний нэгдсэн [/unelgee.gov.mn/](http://unelgee.gov.mn/) цахим системд байршуулсан 3 зорилтын 15 арга хэмжээний хүрээнд хийлээ.

Арга хэмжээнүүдийн биелэлтийг бодлогын зорилгоор нь авч үзвэл:

- 2.2.Уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.

Хяналтад авагдсан 15 арга хэмжээг хэрэгжүүлэхээр тусгагдсан ба биелэлт 70.66 хувьтай /хүснэгт №1/ үнэлгэдлээ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар Монгол улсын хөгжлийн  
2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний үнэлгээний товчоо  
/2024 оны эхний хагас жилийн байдлаар/

Хүснэгт №1

Хэрэгжилт гаргах нийт төсөл, арга хэмжээний тоо		15
Үр дүнтэй	100%	4
Тодорхой үр дүнд хүрсэн	90%	1
	70%	6
Эрчимжүүлэх шаардлагатай	50%	3
	30%	0
Үр дүнгүй	0%	1
Хугацаа болоогүй	Хугацаа болоогүй	-
Хэрэгжилтийн дундаж		70.66%

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар Монгол улсын хөгжлийн  
2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт  
/2024 оны эхний хагас жилийн байдлаар/

Хүснэгт 2

Зорилго	Арга хэмжээни й тоо	Үнэлгээ (хувь)						Хэрэгжилт (хувь)
		100	90	70	50	30	0	
2.2. Уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.	15	4	1	6	3	-	1	70.66%
Нийт дүн	15	4	1	6	3	-	1	70.66%

**2024 оны эхний хагас жилийн байдлаар “үр дүнгүй”-зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй 1 арга хэмжээ байна. Үүнд:**

### 1. 2.2.3.3. Гангийн үйлдвэр байгуулах

2024 оны эхний хагас жилийн байдлаар “Эрчимжүүлэх шаардлагатай”-зорилт нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулж, үйл ажиллагааг эрчимжүүлэх”-зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй 3 арга хэмжээ байна. Үүнд:

1. 2.2.2.2. Хармагтайн зэс, алтны болон Асгатын мөнгөний ордыг ашиглалтад оруулах бэлтгэл ажил хангах 50 оноо.
2. 2.2.3.1. Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах 50 оноо.
3. 2.2.3.4. Ураны олборлолт, худрийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулахад хөрөнгө оруулалт татах 50 оноо.

### Дөрөв. Дүгнэлт

1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар Монгол улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилт 2024 оны эхний хагас жилийн байдлаар 70.66 хувьтай үнэлэгдэв.
2. Монгол улсын хөгжлийн 2024 хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээнүүд нь ЗГУАХ-т батлагдсан арга хэмжээнүүдээс хэрэгжих хугацаа хоцролтой, зөрүүтэй байгаа тул цашид Улсын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахдаа урт дунд хугацааны бодлогын баримт бичгийн хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, хэрэгжих хугацааг уялдуулах,
3. Хэрэгжилт хангалтгүй, үр дүнгүй арга хэмжээнүүд нь тухайн жилд зарцуулсан хөрөнгө, гүйцэтгэл, санхүүжилт тодорхойгүй, хийсэн ажил авч хэрэгжүүлсэн ажлуудын цаг хугацаа тодорхой бус байгаа нь биелэлтийн түвшинг үнэлэх, бодлогын баримт бичгийн төлөвлөлт, хэрэгжилтийг сайжруулах тодорхой санал боловсруулахад хүндрэл үүсгэж байна.

### Тав. Санал, зөвлөмж

1. Улсын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулахдаа урт дунд хугацааны бодлогын баримт бичгийн хүрэх түвшин, шалгуур үзүүлэлт, хэрэгжих хугацааг уялдуулах, тайлант хугацаандаа хэрэгжихүйц, биелэж болохуйцаар төлөвлөхөд анхаарах
2. Хөгжлийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдуулан, тооцоо судалгаа, дүн шинжилгээний үндсэн дээр Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлаар Монгол улсын хөгжлийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжилт хангалтгүй болон тасарсан арга хэмжээний талаар холбогдох арга хэмжээг авах, хэрэгжилт хангалтгүй “үр дүнгүй”-зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй арга хэмжээг хэрэгжүүлэх, эрчимжүүлэх талаар хариуцсан нэгжүүд онцгой анхаарч тусгайлан төлөвлөгөө гарган хэрэгжүүлэгч байгууллагатай хамтран ажиллах, хэрэгжих боломжгүй бол бодлогын баримт бичгээс хасуулах санал бэлтгэх,
3. Төсөл, арга хэмжээг хариуцсан нэгжүүд нь төсөвт өртөг, гүйцэтгэл, санхүүжилтийн хэмжээг нарийн тодорхой тайлагнах,

4. Нэгжүүд Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгагдсан зорилго, арга хэмжээ нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн зорилго, зорилт, хүрэх үр дүн, хэрэгжих хугацаа болон Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан арга хэмжээ, зорилго, зорилт, хүрэх түвшин хэрэгжих хугацаатай хэрхэн уялдаж байгааг анхаарах,
5. Хяналт-шинжилгээ, үнэлгээний явцын болон эцсийн дүгнэлт, зөвлөмжид үндэслэн тухайн бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, нэмэлт, өөрчлөлт оруулах болон шаардлагатай бусад арга хэмжээ авах үйл ажиллагааг холбогдох нэгж, албан тушаалтан хариуцан зохион байгуулах,

Хянасан:

ХШҮДАГ-ЫН дарга

Т.Баасанпүрэв

ХШҮ хийж, танилцуулга боловсруулсан:

ХШҮДАГ-ЫН ЦБМТХ-ИЙН шинжээч

Д.Батнайрамдал



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМНЫ  
УДИРДЛАГЫН ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ  
ТЭМДЭГЛЭЛЭС

2024 оны 06 дугаар сарын 12

Дугаар 12

Улаанбаатар хот

Тайлан хэлэлцэх тухай

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Удирдлагын зөвлөлийн 2024 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн хуралдааны тэмдэглэлд:

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

“Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ын дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд эхний хагас жилийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайлангийн танилцуулгыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын дарга Т.Баасанпүрэв хийв.

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд эхний хагас жилийн байдлаар хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний тайланг холбогдох журмаар тогтоосон хугацаанд нь Эдийн засаг, хөгжлийн яаманд хүргүүлэхээр шийдвэрлэв.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН  
ДАРГА

С.МАГНАЙСҮРЭН

**МОНГОЛ УЛСЫН 2024 ОНД БАРИМТЛАХ БОДЛОГЫН ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛИЙН ХЭРЭГЖИЛТ**

Бодлогын тэргүүлэх чиглэл	Үндсэн зорилт			Дэд зорилт	Хариуцагч байгууллага	Хэрэгжилт тайллагнах бөгөөд 2000 тэмдэгтэд явцаар багтаана./	/Хэрэгжилтийг яваар 2000 тэмдэгтэд	Үнэлгээ
Нэг. Экспортыг нэмэгдүүлнэ	1	1.1.	1.1. Нүүрсний экспортын биет хэмжээг 50 сая /60 сая.тн/ тоннд, зэсийн экспортын биет хэмжээг 1.5 сая тоннд, газрын тосны экспортын биет хэмжээг 6 сая баррельд хүргэж, уул уурхайн салбарын экспортыг нэмэгдүүлнэ.	2024 онд голлох бүтээгдэхүүний экспортын биет хэмжээг нүүрс 60 сая тонн, зэсийн баяжмал 1,500 мянган тонн, төмрийн хүдэр 8,400 мянган тонн, газрын тос 4,850 мянган баррель, алт 20 тонн байхаар төсөөлж байна.	УУХҮЯ	2024 оны 6 дугаар сарын байдлаар 32.1 сая.тн нүүрс, 636.6 мян.тн зэсийн баяжмал, 2.9 сая.тн төмөр, 48.6 мян.тн цайр, 456.9 мян.тн хайлуур жонш, 1.7 сая.бар газрын тос экспортолсон байна.		70
	14	2.2.	Геологи, хайгуулын ажлыг эрчимжүүлэн, ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг нэмэгдүүлж, улмаар ашигт малтмалын батлагдсан неөцийг өсгөнө. Мөн зэсийн ордын ашиглалтыг нэмэгдүүлэх замаар хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.		УУХҮЯ	Холбогдох хууль, журамд заасны дагуу <a href="http://www.tender.gov.mn">www.tender.gov.mn</a> платформ-оор сонгон шалгаруулалтыг зарлан тусгай зөвшөөрлийг олгож байгаа бөгөөд 5 дугаар сард цахимаар сонгон шалгаруулалт зарлагдаагүй. Гүйцэтгэл: Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох ажлын хүрээнд 2024 оны 05 дугаар сарын байдлаар 69.412.89 мянган га талбайг хамарсан 71 талбайд хайгуулын малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг 3 удаа зарлан үнэлгээ хийж, 42 хайгуулын тусгай зөвшөөрлийг шинээр олгосон. Улсын төсөвт 8.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөгөөнд тусгаснаас 34.8 тэрбум төгрөг төвлөрүүлээд байна.		70

Хоёр.Хөрөнгө оруулалтыг нэмэгдүүл нэ.	15	2.3.	Стратегийн ач холбогдол бүхий ашигт малтмалын ордуудын нөөцийг нарийвчлан тогтоож, эдийн засгийн эргэлтэд оруулах замаар Үндэсний баялгийн сангийн тогтолцоог бий болгоно.			УУХҮЯ, ХЭДХЯ, ЗГХЭГ	Өмнөговь аймгийн Цогцэций сумын нутагт орших Тавантолгой чулуун нүүрсний бүлэг ордын Цанхи, Бортзээг болон Оорцогийн хэсэгт 2017-2022 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн нөөцийн шинэчилсэн тайланг ЭБМЗ-өөр хэлэлцүүлж, ордын нөөцийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар хүлээн авч ЭБМЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн СТР-2024-01 дугаар дүгнэлт гарсан.	70
---------------------------------------	----	------	--	--	--	---------------------	---	----

16	2.4.	<p>Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр, нүүрс баяжуулах үйлдвэр, гангийн үйлдвэр болон ураны олборлолт, худрийн баяжмал боловсруулах үйлдвэрүүдийг хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар байгуулж, боловсруулах үйлдвэрийг нэмэгдүүлнэ.</p>	<p>Нүүрс баяжуулах үйлдвэр, ураны олборлолт, худрийн баяжмал боловсруулах үйлдвэрүүдийн мэдээлэл УУБГ-аас гарна</p>	<p>УУХҮЯ</p> <p>Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын түшиглэн байгуулах "Уул уурхай-металлурги-химиийн үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд баригдах "Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ"-ийг Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн 2022.06.22-ны өдрийн өргөтгесэн хуралдаанаар хэлэлцэж хулзэн авсан бөгөөд ЗБХБҮ-ээс ялгарах хүхрийн давхар исэл агуулсан хийг цэвэршуулэн түүнээс элементийн хүхэр үйлдвэрлэх үйлдвэрлэлийн туршилтыг БНХАУ-ын Шинжан Уйгарын ӨЗО-ны Фуюун мухид Шинжаны өнгөт төмөрлөгийн аж үйлдвэр группийн (ХJNM) эзэмшилийн Зэс ба никелийн металлургийн "Хіпхіп Metals" компанийн үйлдвэрлэлийн бусад явуулж байна. Тус туршилтын үр дүнгээр "Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ"-д тодотгол хийж холбогдох зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх хүсэлтийг ирүүлээд байна.</p> <p>Тус үйлдвэрийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд УТП-ийн асфальт бетон хүчилттай 12.62 км авто зам барих ажлын гүйцэтгэл 39%, 4.4 км төмөр зам барих ажлын гүйцэтгэл 85%. Ус хангамж, ариутгах татуургын систем барьж байгуулах ажлын явц 35%, Цахилгаан хангамжийн зураг төслэл боловсруулах ажлын явц 95%-ийн гүйцэтгэлтэй байна.</p>	50

**МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН 2024 ОНЫ ТӨЛӨВЛӨГӨӨНД  
 УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН САЙДЫН ЭРХЛЭХ АСУУДЛААР ТУСГАГДСАН  
 ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ  
 /2024 ОНЫ 06 ДУГААР САРЫН 13-НЫ ӨДРИЙН БАЙДЛААР/**

Хөтөлбөрийн үр дүн	Зорилт /бодлогын үндэслэл/	Төсөл, арга хэмжээ	Шалгур үзүүлэлт,	Хэмжих нэгж	Үр дүнгийн шалгур үзүүлэлт		Санхүүжилт		Хэрэгжилтийн явц	Хэрэгжилтийн
					Суурь түвшин /2022 он/	Зорилто т түвшин /2024 он/	Санхүүжилт, сая.төгрөг	Санхүүжилтийн эх үүсвэрийн ангилал		
1	2	3	4	5	6	7	8	9	10	11
2.2.Уул уурхайн салбар дахь хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлнэ.										
1	2.2.1. Геологи, хайгуулын ажлыг эрчимжүүлж, ашигт малтмалын батлагдсан нөөцийг нэмэгдүүлнэ.	AX-4.2.24, МУХТЖҮЧ-4.2.1, ЗГУАХ-3.2.3	2.2.1.1. Орчин үеийн дэвшилтэт технологи ашиглан агаарын геофизикийн цогц судалгааны ажлыг гүйцэтгэх	Нислэгт хамрагдсан талбай, хувь	0	20	40,732.00	Улсын төсөв	Монгол орны Өмнөд бүсийг хамарсан Агаарын геофизикийн цогцолбор судалгааны "Агаарын геофизик-2024" төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендэрийг зохион байгуулсан. Энэ тенцерт "Геологийн судалгаа, шинжилгээний төв" ТӨҮГ, XCalibur компанийн түншлэл шалгарч, ажил гүйцэтгэх гэрээг 2024.05.08-ны өдөр байгуулан төслийн судалгааны ажлыг эхлүүлээд байна. Мөн агаарын геофизикийн 1:200000-ны масштабтай Ховд-2020 төслийн үр дүнгийн тайланг ЭБМЗ-ийн 2024 оны 03 дугаар сарын 25-ны өдрийн УТХ-2024-04 хуралдаанаар хэлэлцэн хулээн авсан. Төслөөр 104,044 кв.км талбай буюу Монгол орны нутаг дэвсгэрийн 6.6 %-ийн хэмжээнд агаарын	100

									цогцолбор судалгаагаар бүрхсэн үр дүнтэй байна.		
2		AX-4.2.24, МУХТЖҮЧ- 4.2.1, ЗГУАХ-3.2.5	2.2.1.2.Газрын ховор элемент болон өндөр технологийн түүхий эдийн хэтийн төлөвийн судалгаа хийх	Талбайн хэмжээ	Km2	41,153.58	63,168	7,963.04	Улсын төсөв	<p>Өнлөр технологийн түүхий эдийн чиглэлээр 2 төслийг хэрэгжүүлж байна. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны А/379 тоот тушаалаар "Өндөр технологийн түүхий эд-2" төслийн 2024 оны төсвийг баталсан. Ажлын үр дүнтэй уялдуулан төслийн 2024 оны төсөл, төсвийн тодотголыг ЭБМЗ-ийн 2024 оны 03 сарын 05-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн холбогдох дүгнэлт гарсан. Төслийн ажлыг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.</li> <li>"Өндөр технологийн түүхий эд-1" төслийн үр дүнгийн тайланг 2024 оны 06 сарын 07-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэн хүлээн авсан байна.</li> </ol>	100
3		AX-4.2.24, МУХТЖҮЧ- 4.2.1, ЗГУАХ-3.2.4	2.2.1.3.Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг хөгжүүлж, цахимжуулах ажлын хүрээнд "Геологийн баримт-1-2022" төслийг хэрэгжүүлж байна. Энэхүү төслөөр 2024 оны эхний хагас жилд:	химжсан мэдээллийн хэмжээ	Хувь	5	25	899.45	Улсын төсөв	<p>Үндэсний геомэдээллийн нэгдсэн санг хөгжүүлж, цахимжуулах ажлын хүрээнд "Геологийн баримт-1-2022" төслийг хэрэгжүүлж байна. Энэхүү төслөөр 2024 оны эхний хагас жилд:</p> <ol style="list-style-type: none"> <li>1. Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2023 оны А/379 дүгээр тушаалаар Улсын төсвийн хөрөнгөөр 2024 онд төсвийг баталсан.</li> <li>2. ЭБМЗ-ийн 2024 оны 03 сарын 06-ны өдрийн хуралдаанаар төслийн 2024 оны төсөл, төсвийн тодотголыг хэлэлцэн батлах тухай дүгнэлт гарсан.</li> </ol>	100

									3. Эхний хагас жилд Үндэсний геологи, эрдэс баялгийн мэдээллийн нэгдсэн санг Илрэл-3808, Худаг-4575, Цооног-4317, Шлихийн хүрээ-2705, Өрөмдсөн цооног-400, Эрдэсжээн цэг-155, Давхарга зүйн сан-457, Горизонт-61, Интрузив чулуулгийн сан-1914, Эффузив чулуулгийн сан-360, Палеонтологийн олдворын дэд сан-2171, Үнэмлэхүй насны сан-1119, Нийтлэл-875 буюу нийт 7160 мэдээллээр баяжуулсан.	
4	АХ-4.2.11, МУХТЖҮЧ- 4.2.1, ЗГУАХ-3.2.5	2.2.1.4.Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл олголтыг хялбаршуулж, нэмэгдүүлэх	Олгосон тусгай зөвшөөрөл	тоо	50	200	200.00	Улсын төсөв	Ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрлийг сонгон шалгаруулалтаар олгох ажлын хүрээнд 2024 оны 05 дугаар сарын байдлаар 69.412.89 мянган га талбайг хамарсан 71 талбайд хайгуулын малтмалын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг 3 удаа зарлан үнэлгээ хийж, 42 хайгуулын тусгай зөвшөөрлийг шинээр олгосон. Улсын төсөвт 8.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөгөөнд тусгаснаас 34.8 тэрбум төгрөг төвлөрүүлээд байна.	100

5	2.3эс, алт, мөнгөний ордын ашиглалтыг нэмэгдүүлнэ.	AX-4.2.14, МУХТЖҮЧ- 4.2.11, ЗГУАХ-3.2.1	2.1.Цагаан суварын зэс, молибденийн ордыг ашиглалтад оруулах	Барилгын ажлын гүйцэтгэл	Хувь	69	100	250,384. 60	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	Уулын үйлдвэрийн тоног төхөөрөмжийн угсралт, туршилт, тохирууллын ажлыг 2024 онд хийж баяжуулах үйлдвэрийг ашиглалтад оруулахаар төлөвлөн ажиллаж байна. 2023 онд дараах барилга угсралтын ажлыг гүйцэтгээд байна. <ul style="list-style-type: none"> <li>Анхан бутлуурын хүчтэгээн хананы угсралт дууссан,</li> <li>Барилга болон тоног төхөөрөмжийн суурин цутгалт хийгдсэн.</li> <li>Барилгын металл хийц угсралтыг хийсэн.</li> </ul> Үндсэн болон туслах тоног, материалын тээврийг хийж байна. Мөн туслах тоног төхөөрөмжийн захиалга, үйлдвэрлэл хэвийн үргэлжилж байна.	70
6			2.2.2.2.Харма гтайн зэс, алтны болон Асгатын мөнгөний ордыг ашиглалтад оруулах бэлтгэл ажил хангах	Арга хэмжээний хэрэгжилт	Хувь	-	100	-	-	"Эрдэнэс Монгол" ХХК Төлөөлөн удирдах зөвлөлийн 2023 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн №48 тогтоолоор Асгатын мөнгөний ордод ордын геолги хайгуулын ажлыг гүйцэтгэх, уул техникийн нөхцөл тодорхойлох, уурхайн баримт материалын зураг боловсруулах, нөөцийн тайлан, урьдчилсан техник эдийн засгийн үндэслэл боловсруулж үйлдвэрлэлийн нөөцийг тодорхойлох чиг үүрэг бүхий "Asgat төслийн нэгж"-	50


										буу Топо геодезийн ажилд гүйцэтгээр шалгарсан компанитай гэрээ байгуулсан. - Асгатын мөнгөний ордын нөөцийг олон улсын нөөц баялгийн /jogs/ ангилалд нийцүүлэх хайгуулын ажлын төлөвлөгөө боловсруулан түүний дагуу нэмэлт хайгуулын ажил гүйцэтгэх, хагас үйлдвэрлэлийн технологийн туршилт хийх, үр дүнгийн тайлан оловсруулж батлуулах ажлын тендер шалгаруулалтыг ТХААГазраас зарлан 2024.02.26-ний өдөр нээлт хийгдсэн. Тухайн тендерт 3-н компани материал ирүүлсэн оловч тендерийн ерөнхий шаардлагыг хангаагүй. Иймд Төрийн худалдан авах ажиллагааны газар дахин нээлтэй тендер шалгаруулалтыг агаар 2024.04.19-ны өдөр нээлтийг хийгдсэн. Тухайн тендерт 3-н компани материал ирүүлсэн оловч тендерийн ерөнхий шаардлагыг хангаагүй. Иймд Төрийн худалдан авах ажиллагааны газраас 2024 оны 05 дугаар сарын 03-нд дахин тендерийг зарлаад 5 дугаар сарын 29-ны өдрийн үнэлгээний хорооны шийдвэрээр эхний эзлжид ажил гүйцэтгэх компани шалгарсан. Хэвтээ ам-1, Хэвтээ ам-1а, Хэвтээ ам-2, Хэвтээ ам-3,
--	--	--	--	--	--	--	--	--	--	---

												Xэвтээ ам-4, Xэвтээ ам-5-уудыг ашиглах боломжийг хангах, нарийвчилсан хайгуулын ажил эхлүүлэх бэлтгэл ажлын хүрээнд дараах тендерүүдийг зарласан: - ЭМГЛ/202306084 дугаартай "Асгатын ордын уурхайн хэвтээ зам засах" тендерийн ажилд гүйцэтгэгчээр шалгарсан компанитай гэрээ байгуулсан. Гэрээний дагуу гүйцэтгэгч компани нь зам засах ажлаа 5 дугаар сараас эхлүүлсэн. - ЭМГЛ/202306085 дугаартай "Асгатын ордын уурхайн хэвтээ зам нээх" тендерт шалгарсан компанитай гэрээ байгуулах тухай зөвлөмж ТХААГ-аас 2023.11.29-нд ирсэн. Ажил гүйцэтгэгч компанитай байгуулахаар ажиллаж байна. - ЭМГЛ/202306088 дугаартай "Асгатын мөнгөний ордын хэвтээ малталтуудын турван хэмжээст зураглалын ажил хийх, эрсдэл аюулгүй байдлын үнэлгээ хийх" зөвлөх үйлчилгээний гүйцэтгэгчээр шалгарсан компанитай гэрээ байгуулсан. - ЭМГЛ/202306087 дугаартай "Асгатын мөнгөний ордод гадаргуугийн зураглал буюу Топо	
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

									геодезийн зөвлөх" үйлчилгэний ажилд шалгарсан компанитай гэрээ байгуулсан.		
7		AX-4.2.14, МУХТЖҮЧ- 4.2.11, ЗГҮАХ-3.2.7	2.2.3.1.Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулах	Барилгын ажлын гүйцэтгэл	Хувь	-	30	23,263.6 8	Бусад эх үүсвэр	Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ЫН түшиглэн байгуулах "Уул уурхай-металлурги-химиин үйлдвэрийн цогцолбор" үйлдвэрлэл, технологийн паркийн хүрээнд баригдах "Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ"-ийг Эрдэс баялагийн мэргэжлийн зөвлөлийн 2022.06.22-ны өдрийн өргөтгөсөн хуралдаанаар хэлэлцэж хүлээн авсан бөгөөд ЗБХБҮ-ээс ялгарах хүхрийн давхар исэл агуулсан хийг цэвэршүүлэн түүнээс элементийн хүхэр үйлдвэрлэх үйлдвэрлэлийн туршилтыг БНХАУ-ын Шинжан Уйгарын ӨЗО-ны Фуюун мужид Шинжаны өнгөт төмөрлөгийн аж үйлдвэр группийн (XJNM) эзэмшлийн Зэс ба никелийн металлургийн "Xinxin Metals" компанийн үйлдвэрлэлийн бүсэд явуулж байна. Тус туршилтын үр дүнгээр "Зэсийн баяжмал хайлуулах, боловсруулах үйлдвэрийн ТЭЗҮ"-д тодотгол хийж холбогдох зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх хүсэлтийг ирүүлээд байна.	50

2.2.3.  
Боловсруулах  
үйлдвэрийг  
нэмэгдүүлнэ.

										Тус үйлдвэрийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлын хүрээнд ҮТП-ийн асфальт бетон хүчилттай 12.62 км авто зам барих ажлын гүйцэтгэл 39%, 4.4 км төмөр зам барих ажлын гүйцэтгэл 85%. Ус хангамж, ариутгах татуургын систем барьж байгуулах ажлын явц 35%, Цахилгаан хангамжийн зураг төсөл боловсруулах ажлын явц 95%-ийн гүйцэтгэлтэй байна.	
8			2.2.3.2. "Эрдэн эс- Тавантолгой" ХК-ийн нүүрс баяжуулах үйлдвэр байгуулах ажлыг Үргэлжлүүлэх	Барилгын ажлын гүйцэтгэл	Хувь	20	50	89,455.6 2	Бусад эх үүсвэр	2024 оны 04-р сарын 30-ны өдрийн байдаа: • Үндсэн үйлдвэрийн метал хийц, сендвичэн хана, дээврийн угсралт, • Үндсэн тоног төхөөрөмжийн угсралт сууринуулалт, • Гадна ус, дулааны шугам хоолойн ухлагын ажил, • Үйлдвэрийн удирдлагын тоног төхөөрөмжийн угсралт сууринуулалт, • Иргэний барилга байгууламжийн дотор заслын ажил тус тус хийгдэж байна.  Нүүрс баяжуулах үйлдвэрийн "Үйлдвэрийн хэсгийн барилга байгууламжуудын" барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээг 2024 оны 04 дугээр сарын	70

									24-ний өдөр Өмнөговь аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газраас авсан. Төслийн ашиглалтад орох хугацаатай уялдуулан эхний ээлжинд 192 ажлын байранд нэн яарлтай сонгон шалгаруулалт хийх зорилгоор Засгийн газрын Онцгой бүрэн эрхт төлөөлөгчийн 2024 оны А/81 тушаалаар "Сонгон шалгаруулалтын ажлын хэсэг"-ийг байгуулж сонгон шалгаруулалтын ажлыг гүйцэтгэж компанийн удирдлагуудад танилцуулж баталгаажуулахаар ажиллаж байна. НБҮ-ийн төслийн гэрээнд заасны дагуу Ерөнхий гүйцэтгэгч үйлдвэрийн ажилчдын сургалтыг 2024 оны 05 дугаар сарын 10-ны өдөр эхлүүлэхээр төлөвлөсөн.		
9		АХ-4.2.14, МУХТЖУЧ- 3.2.4, ЗГУАХ-3.7.13	2.2.3.3.Гангийн үйлдвэр байгуулах	Барилгын ажлын гүйцэтгэл	Хувь	-	30	1,000,00 0.00	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	Бэрэн групп ХХК-ны 2014 оноос Орхон аймагт хэрэгжүүлж байгаа 200 мян.тн/жил хучин чадалтай ган бүтээгдэхүүний үйлдвэрийн төслийн хэрэгжилт 75 орчим хувьтай байна. Тус компани нь Монгол Улсын Хөгжлийн банкнаас 2014 онд 22.7 сая ам.доллар, 2018 онд 4.5 сая ам.доллар, нийт 27.2 сая ам.долларын зээлийн санхүүжилт авсан ба	0

									үйлдвэр ашиглалтад орж үйл ажиллагаа эхлүүлээгүйн улмаас уг зээл эргэн төлөгдөөгүй байна. Цаашид үйлдвэрийг ашиглалтад оруулахад шаардагдах 30.7 тэрбум төгрөгийн санхүүжилт шийдэгдээгүй байгаа ба Хөгжлийн банкны зээл, ерийн асуудлаар "Бэрэн групп" ХХК-ийг хууль хяналтын байгууллагаас шалгаж, үйл ажиллагаа явуулах боломжгүй болсон ба 2023 оныг дуустал хугацаанд (2024.05.30 буюу одоог хүртэл) төслийн үлдэгдэл санхүүжилтийг шийдвэрлэх, бүтээн байгуулалтыг үргэлжлүүлэх талаар аливаа үйл ажиллагаа зогсонги байдалд орсон.	
10	АХ-4.2.14, МУХТЖУЧ- 4.2.1, ЗГҮАХ-3.2.7	2.2.3.4.Ураны олборлолт, худрийн баяжмал боловсруулах үйлдвэр байгуулахад хөрөнгө оруулалт татах	Хөрөнгө оруулалтын гэрээ	Тоо	-	1	1,000,00 0.00	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	Монгол Улсын Ерөнхийлөгчийн Бүгд Найрамдах Франц хийсэн айлчлалын хүрээнд уг хөрөнгө оруулалтын гэрээний протокол байгуулсан бөгөөд үүнтэй холбогдуулан Ерөнхий сайдын 2023 оны 164 дүгээр захирамжаар Оrona майнинг ХХК-аас ирүүлсэн хөрөнгө оруулалтын гэрээний төслийг Монгол Улсын Үндсэн хууль, олон улсын гэрээ, холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах, хөрөнгө оруулагч талтай	50

											хэлэлцээ хийх уүрэг бүхий Ажлын хэсгийг Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалангаар ахлуулан шинэчлэн байгуулсан. Улмаар ЗГХЭГ-ын даргын 2023 оны 97 дугаар тушаалаар Ажлын дэд хэсгүүдийг байгуулсан бөгөөд Олборлолт, үйлдвэрлэл, технологийн асуудал хариуцсан дэд Ажлын хэсгийг Уул уурхай, хунд үйлдвэрийн сайд Ж.Ганбаатараар ахлуулсан. Ажлын дэд хэсэг 3 удаа хуралдаж, 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдөр хөрөнгө оруулагч Орано компанийн төлөөлөлтэй хэлэлцээр хийж, холбогдох саналаа Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга Д.Амарбаясгалангаар ахлуулсан Ажлын хэсэгт тус тус хүргүүлээд байна. Одоогоор бусад Ажлын дэд хэсгүүд Орано компанийн төлөөлөлтэй хэлэлцээр хийж байна. Энэхүү Хөрөнгө оруулалтын гэрээ байгуулагдсанаар төслийн хугацаанд нийт 8.6 тэрбум долларын борлуулалтын орлого олж, 5.03 тэрбум долларын үйл ажиллагааны зардал гарган, 3.5 тэрбум долларын татварын өмнөх ашигтай ажиллахаар, нийт
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	---

									1.6 сая.долларын хөрөнгө оруулалттайгаар ТЭЗҮ-ний тодотголд тусгасан байна.		
11		АХ-4.2.14, МУХТЖҮЧ- 4.2.11, ЗГҮАХ-3.2.8	2.2.3.5.Газрын тос дамжуулах хоолой барих төслийг хэрэгжүүлэх	Барилгын ажлын гүйцэтгэл	Хувь	0	20	260,643. 00	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	Төслийн гүйцэтгэл 2024.05.29-ний өдрийн байдлаар хоолой цувих ажил нийт 256.7 км, хоолойн гагнуурын ажил нийт 232.1 км хийгдээд байна. гүйцэтгэл 2024.5.01- ний байдлаар 52,0-тай.	100
12		АХ-4.2.14, МУХТЖҮЧ- 4.2.11, ЗГҮАХ-3.2.8	2.2.3.6.Газрын тос боловсруулах үйлдвэр барих	Барилгын ажлын гүйцэтгэл	Хувь	7.7	36.4	250,000. 00	Гадаадын зээл, тусламж	EPC01-99,8%, EPC02- 1,07%, EPC03-2,23%, EPC04-11,58%-ийн тус тус гүйцэтгэлтэй, ерөнхий дүнгээр 12,49%-ийн гүйцэтгэлтэй байна..	70
13		АХ-4.2.14, МУХТЖҮЧ- 4.2.11, ЗГҮАХ-3.2.7	2.2.3.8."Эрдэн эт үйлдвэр" ТӨҮГ-ыг тушиглэн "Уул уурхай- металлурги- химиин үйлдвэрийн цогцолбор" үй- лдвэрлэл, технологийн п- аркийн дэд бүтцийг байгуу- лах	Барилгын ажлын гүйцэтгэл	Хувь	50	100	68,917.2 6	Бусад эх үүсвэр	Авто замын бүтээн байгуулалтын талаар - УТП-ийн асфальт бетон хүчилттай 12.62 км авто зам барих /Багц-1/ гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 2023 оны 03 дугаар сарын 14-ний өдөр гэрээ байгуулсан. Авто замын гэрэлтүүлгийн /Багц- 2/ ажлын гүйцэтгэгчийг мөн адил сонгон шалгаруулж, 2023 оны 03 дугаар сарын 07-ны өдөр гэрээ байгуулсан. Ажил гэрээ, төлөвлөгөөний дагуу явагдаж байна, гүйцэтгэл 39%-тай. - Автозамын захиалагчийн хяналтын зөвлөх үйлчилгээний тендер "Мөнхөд ашдын зам" ХХК шалгарч, гэрээ байгуулан ажиллаж байна. <b>Төмөр замын бүтээн байгуулалтын талаар</b>	70

									<ul style="list-style-type: none"> <li>- УТП-ийн нийт 4.4 км төмөр зам барих ажлын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, 2023 оны 01 дүгээр сарын 11-ний өдөр гэрээ байгуулсан. Ажил гэрээ, графикийн дагуу явагдаж байна, гүйцэтгэл 85%-тай.</li> <li>- УТП-ийн төмөр замыг барьж байгуулах ажилд зохиогчийн хяналт тавих ажлын гэрээг уг төмөр замын зураг төслийг боловсруулсан компанийт 2023 оны 5 дугаар сард байгуулан, хяналт тавин ажиллаж байна.</li> <li>- Төмөр замын захиалагчийн хяналтын зөвлөх үйлчилгээний тендерт "Рэйлвэй консалтинг Сервис" ХХК шалгарч, гэрээ байгуулагдсан.</li> <li><b>Ус хангамж, ариутгах татуургын систем барьж байгуулах ажлын талаар</b></li> <li>- Ус хангамж, ариутгах татуургын систем барьж байгуулах ажлын тендерийг 2022 оны 05 дугаар сараас эхэн зарласан боловч СЯ, ШӨХТГ-т гомдол гарах, тендер хүчингүй болох зэрэг шалтгаануудаар өнөөдрийг хүртэл гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж чадаагүй байна. 2023.06.23-ны өдөр шүүх хурал болж, тендерт оролцогчийн гомдлыг</li> </ul>
--	--	--	--	--	--	--	--	--	--

									ундэслэлгүй гэж шийдвэрлэж, тендерийг дахин зарлах эрх зүйн байдал үүссэн. Гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендерийг AYXAAX-с 2023.08.03-ны өдөр дахин зарласан оловч ШӨХТГ-т гомдол гарсан тул гомдлыг хянан шалгах үйл ажиллагаа үргэлжилж, Захиргааны хэргийн давж заалдах шатны шүүхийн шийдвэр гарч "Б-софт" ХХК-тай 2023.12.13-д гэрээ байгуулсан. Гэрээний хугацаа 2024.12.20-нд дуусна. Бохир усны Ф400мм голчтой ширмэн хоолой 790м, HDPE 110 мм голчтой 1570м, 250мм голчтой 3126м, нийт 5486 м шугамыг угсарч дууссан. Бохир усны Өргөлтийн насос станц №1,2,3,5 -ын суурийн газар шорооны ажил хийж суурийн бэлтгэл бетон суурь, ханын цутгалт, худгийн цутталт хийсэн. Авто зам, төмөр замын 4 хэсэг газарт бохир усны 104м урттай шугамыг сувлэж байрлуулсан. Цэвэр усны 300 мм 4350м урт цайдсан ган хоолойг угсарч дууссан. Ажлын явц 35%. <b>Цахилгаан хангамжийн</b> <b>зураг төсөл</b> <b>оловсруулах ажлын</b> <b>талаар</b>	
--	--	--	--	--	--	--	--	--	--	--

											"Бодит чадал" ХХК-ийн боловсруулсан ТЭЗҮ-ийг Эрчим хүчний яамны ШУТГЗ-өөр 2022.04 сард хэлэлцүүлэн батлуулсан. ТЭЗҮ-ийн дагуу 64.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 220/110/35 кВ-ын Оюут дэд станц, 110/35/10 кВ-ын "УТП" дэд станц, 220 кВ, 110 кВ-ын ЦДАШ-уудийг барьж байгуулна. ТЭЗҮ, Диспетчерийн үндэсний төв ТӨХХК-ийн горимын тооцоо зэргийг үндэслэн, ЭХЯ-наас УТП-ийн цахилгаан хангамжийн техникийн нөхцөлийн дагуу 2022.10.28-ны өдөр цахилгаан хангамжийн нарийвчилсан зураг төсөл боловсруулах ажлын даалгаврыг боловсруулан ирүүлсэн. Үйлдвэрийн газрын Зураг төслийн хүрээлэн гүйцэтгэж буй 220 кВ-ын Оюут дэд станц, 220 кВ-ын ЦДАШ-ын зураг төсөлд ДҮТ ТӨХХК-тай гэрээг байгуулан ЭХЯ-аас олгосон Техникийн нөхцөлийн дагуу 220 кВ-ын Оюут дэд станцад Хуурмаг чадал компенсацлах төхөөрөмжийн тооцоог гүйцэтгүүлж, холбогдох байгууллагуудтай зөвшилцөх ажлууд хийгдэж. Ажлын явц 90%. "Эрчим хүчний эдийн засгийн хүрээлэн" ТӨААТҮГ-ын гүйцэтгэж буй 110 кВ-ын дэд станц, 110
--	--	--	--	--	--	--	--	--	--	--	--

									кв-ын ЦДАШ-уудын зураг төсөл ЭХҮТ ТӨХХК-ийн магадлааар зураг төсөл хянагдаж, ерөнхий дүгнэлт гарч 2024.04.10-нд "Эрдэнэт үйлдвэр" ТӨҮГ-ын Ерөнхий захирлын тушаалаар батлагдсан ажлын хэсэгт 100% хүлээлгэн ёгсөн. Нийт ажлын явц 95%. Улсын тусгай хэрэгцээнд авсан газрыг тусгаарлах, хашаалах ажлын талаар Нийт 16 км хашаа баригдахаас 15 км баригдсан. Гэрээний хугацааг 2024.07.01 хүртэл сунгасан. Газрын хил хязгаар, дэд бүтцийн зураг төслийн давхцал үүссэн нь гэрээ сунгах шалтгаан болсон. Ажлын явц 91%.	
14	АХ-4.2.14, МУХТЖУЧ- 4.2.11, ЗГУАХ-3.2.7	2.2.3.9.Дорног овь аймагт "Алтан ширээт" аж үйлдвэрийн парк байгуула х	Барилгын ажлын гүйцэтгэл	Хувь	25	60	369,930. 00	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	"Инфинити спейс" ХХК-иас 2024 оны 3 дугаар сарын 28- ны өдрийн 24/21 дугаар албан бичгээр ирүүлсэн татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх тухай турван талт гэрээ байгуулах арга хэмжээ авч ёгех хүсэлт ирүүлснийг Засгийн газрын 2023 оны 337 дугаар тогтоолоор батлагдсан "Татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх, татвараас чөлөөлөх журам"-д нийцүүлэн бүрдлийг хангуйж, УҮХҮ-ийн сайдын 2024.04.09-ны өдрийн 01/792 дугаар албан бичгээр Сангийн сайдад хүргүүлсэн бөгөөд Сангийн сайдын 2024	70

									оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 01/2780 дугаар албан бичгээр ирүүлсний дагуу "Инфинити спейс" ХХК-иас ирүүлсэн хүсэлттэй холбогдох баримт бичгийг нөхөн бүрдүүлж УУХҮ-ийн сайдын 2024.04.25-ны өдрийн 01/927 дугаар алба бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн. -Сангийн сайдын 2024 оны 04 дүгээр сарын 25-ны өдрийн 01/3105 дугаар албан бичгээр ирүүлсэн "Инфинити спейс" ХХК-ийн импортоор оруулж ирэх, техник, тоног төхөөрөмж, түүний иж бүрдэлд ногдуулах гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх талаар Засгийн газрын тогтоолын төсөлд 4 санал боловсруулж УУХҮ-ийн сайдын 2024.04.29-ны өдрийн 01/946 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлсэн бөгөөд ЗГ-ын 2024.05.01-ны өдрийн "Татвар төлөх хугацаа сунгах тухай" 191 дугаар тогтоолыг батлуулсан. -Өнөөгийн байдлаар тус ҮТП-ийн хүрээнд баригдах коксын үйлдвэрийн газар, шороо, суурийн цутгалтын ажлыг бүрэн дуусгаж, 2024 оны 4 дүгээр сараас коксын уухны эхний 2 камерины өрлөгийн ажлыг эхлүүлсэн, гүйцэтгэл 30% байна.
--	--	--	--	--	--	--	--	--	--

15	АХ-4.2.14, МУХТЖҮЧ- 4.2.11, ЗГУАХ-3.2.7	2.2.3.10.Дорн оговь аймгийн Хөвсгөл сумын ""Гэрэл т говь" кокс, металлургийн үйлдвэр" үйлдвэрлэл, т ехнологийн парк байгуулах	Барилгын ажлын гүйцэтгэл	Хувь	35	100	375,000. 00	Гадаад, дотоодын хөрөнгө оруулалт	ҮТП-ийн салбар төмөр замын бүтээн байгуулалт 75%, Нүүрс баяжуулах үйлдвэрийн бүтээн байгуулалт 70%, металлургийн коксын үйлдвэрийн бүтээн байгуулалт 15%, паркийн талбайн оффис зэрэг бусад дэд бүтцийн ажил 100% -ийн гүйцэтгэлтэй байгаа бөгөөд төслийн нийт бүтээн байгуулалт 38 %-ийн гүйцэтгэлтэй байна.  Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.4-д заасны дагуу тус ҮТП-ийн бүрэлдэхүүнд баригдах Нүүрс баяжуулах, кокс эрчим хүчиний үйлдвэрийн тоног төхөөрөмжийн татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх гурван талт гэрээ байгуулах тухай "Си Өү Эй Эл" ХХК-иас ирүүлсэн хүсэлтийн бүрдүүлбэрийг Засгийн газрын 2023 оны 09 дүгээр сарын 13-ны өдрийн 337 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Татвар төлөх хугацааг сунгах, хэсэгчлэн төлүүлэх, татвараас чөлөөлөх журам"-ын дагуу хангулж, асуудлыг тус журмын дагуу шийдвэрлэж өтөх хүсэлтийг ҮҮХҮ-ийн сайдын 2024.05.16-ны өдрийн 01/1116 дугаар албан бичгээр Сангийн яаманд хүргүүлэв.	90
ҮНЭЛГЭЭНИЙ ДҮН										

2024.06.14